

“ДАРХАН СЭЛЭНГИЙН ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ”

Хувьцаат компани

2024 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн
**САНХҮҮГИЙН ТАЙЛАН БА ХАРААТ БУС
АУДИТОРЫН ТАЙЛАН**



“ДАРХАН СЭЛЭНГИЙН ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ” ХК

Байгууллагын талаарх мэдээлэл

Үүсгэн байгуулах шийдвэр	“ДАРХАН СЭЛЭНГИЙН ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ” ХК (Цаашд “Компани” гэх) нь 2005 оны 7-р сарын 21-ний өдрийн хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоолоор хувьцаат компани болон шинэчлэн зохион байгуулагдсан.		
Гэрчилгээ	2005 оны 10-р сарын 11-ний өдөр Монгол улсын Улсын Бүртгэлийн Ерөнхий Газарт бүртгүүлж, Улсын бүртгэлийн 2688565 регистрийн дугаар бүхий 9010001004 тоот улсын бүртгэлийн гэрчилгээ авсан.		
Үндсэн үйл ажиллагаа	“Компани”-ийн үндсэн үйл ажиллагаа нь Цахилгаан эрчим хүч түгээх, цахилгаан эрчим хүчийг хангах, Цахилгаан эрчим хүчний шугам болон тоног төхөөрөмжийн үйлдвэрлэл, угсралт, засвар, үйлчилгээ хийх, гадаад дотоод худалдаа эрхлэх зэрэг болно.		
Тусгай зөвшөөрөл	Эрчим хүчний тухай хуулийн 16 дугаар зүйлийн дагуу Эрчим хүчний зохицуулах газраас Дархан-Уул, Сэлэнгэ, Төв аймгийн нутаг дэвсгэрт Цахилгаан түгээх тусгай зөвшөөрлийг 2015 оны 10 сарын 26-ны өдрөөс 20 жилийн хугацаатай авсан. Мөн Эрчим хүчний тухай хуулийн 17 дугаар зүйлийн дагуу Эрчим хүчний зохицуулах газраас Дархан-Уул, Сэлэнгэ, Төв аймгийн нутаг дэвсгэрт Цахилгаанаар зохицуулалтай хангах тусгай зөвшөөрлийг 2015 оны 10 сарын 26-ны өдрөөс 20 жилийн хугацаатай авсан.		
Хувьцаа эзэмшигч	Хувьцааны тоо (ширхэг)	Хувьцааны нэг бүрийн үнэ (төгрөг)	
	10,385,116	100.00	
Гүйцэтгэх Удирдлага	Гүйцэтгэх захирал	Ц.Хангай	
	Ерөнхий нягтлан бодогч	Л.Эрдэнэ-сүгар	
Байнгын хаяг	ДАРХАН СЭЛЭНГИЙН ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ ХК Дархан-Уул сум 3-р баг Дархан-Уул аймаг, Монгол улс		
Аудитор	“ЭВИДЕНСЕ АУДИТ” ХХК Хоймор оффис 502 тоот Алтайн гудамж Сүхбаатар дүүрэг, 9-р хороо, Улаанбаатар хот, Монгол Улс		

2024 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болсон
санхүүгийн тайлан бэлтгэх болон батлах талаарх
Удирдлагын хариуцлагын мэдэгдэл

Энэхүү тайлангийн 3-4 дахь хуудсанд тусгагдсан хараат бус аудиторын тайланд дурдсан хараат бус аудиторын дүгнэлтэй хамт уншиглах дараах мэдэгдэл нь “ДАРХАН СЭЛЭНГИЙН ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ” Хувьцаат Компанийн (Цаашид “Компани” гэх) 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн санхүүгийн тайлантай холбоотой удирдлагын үүрэг хариуцлага болон аудиторын хариуцлагыг тусад нь илэрхийлэх үүднээс хийгдсэн болно.

“Компани”-ийн удирдлага нь эдгээр санхүүгийн тайлангуудыг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (“СТОУС”)-ын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй болно. Бид эдгээр санхүүгийн тайлантай холбоотой үүрэг хариуцлагаа ухамсарлан, санхүүгийн тайлангаа Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (“СТОУС”), Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох заавар журмын дагуу үнэн зөв бэлтгэсэн гэдгээ баталж байна.

Компанийн 2024 оны 12-р сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн санхүүгийн тайланг гаргахыг зовшоорч батлав.

Ц.ХАНГАЙ
Гүйцэтгэх захирал

Л.ЭРДЭНЭСУГАР
Ерөнхий нягтлан бодогч

Огноо: 2025 оны 2 дугаар сарын 17-ны өдөр



“ЭВИДЕНС-АУДИТ” ХХК

Аудит, хөрөнгийн үнэлгээ, аудитсорсинг
Монгол улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
9-р хороо, 7-р хороолол, Алтайн гудамж, 281,
Хойморь оффис, 502 тоот, Регистр № 5211875,
Утас, факс: 976-7000-7121
E-mail: info@evidenceaudit.mn
Огноо: 2025 оны 02 сарын 17 № 03/2025

“ДАРХАН СЭЛЭНГИЙН
ЦАХИЛГААН ТҮГЭЭХ
СҮЛЖЭЭ” ХК-ийн
Удирдлагад

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

Санхүүгийн тайлангийн талаарх аудитын тайлан

Санал дүгнэлт

Бид “Дархан Сэлэнгийн цахилгаан түгээх сүлжээ” ХК-ийн (цаашид “Компани” гэх)-ийн дараах тайлангуудаас бүрдсэн санхүүгийн тайлангуудад аудит хийлээ.

- 2024 оны 12 дугаар сарын 31-нээрх санхүүгийн байдлын тайлан
- Энэ өдрөөрх жилийн дэлгэрэнгүй орлогын тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон
- Нягтлан бодох бүртгэлийн томоохон бодлогуудын хураангуйг агуулсан санхүүгийн тайлангийн тэмдэглэлүүд

Бидний дүгнэлтээр, “Дархан Сэлэнгийн цахилгаан түгээх сүлжээ” ХК -ийн 2024 оны 12 дугаар сарын 31-нээрх санхүүгийн байдал ба уг өдрөөр дуусгавар болсон жилийн санхүүгийн үр дүн болон мөнгөн гүйлгээ нь бүх материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн байна.

Дүгнэлтийн Үндэслэл

Бид энэхүү аудитын ажлыг Аудитын Олон Улсын Стандарт (АОУС)-уудын дагуу хийж гүйцэтгэв. Уг стандартуудын дагуу хүлээсэн үүрэг хариуцлагаа энэ тайлангийнхаа “Санхүүгийн Тайлангийн Аудитад хүлээх Аудиторын Үүрэг Хариуцлага” гэсэн хэсэгт харуулав. Бид Нягтлан бодогчдын ёс зүйн дүрэм болон Монгол улсын мэргэшсэн нягтлан бодогчдын ёс зүйн дүрмийн санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой ёс зүйн зохих шаардлагуудын дагуу тус компаниас хараат бус бөгөөд эдгээр ёс зүйн шаардлагуудад нийцүүлэн бусад ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно. Олж авсан аудитын баримт нотолгоо нь бидний гаргасан дүгнэлтийн үндэслэл болоход хангилттай, тохиромжтой гэж итгэж байна.

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН (үргэлжлэл)

Удирдлага болон Засаглах эрх мэдэл бүхий этгээдүүдийн Санхүүгийн тайланд хүлээх үүрэг хариуцлага

Компанийн удирдлага эдгээр санхүүгийн тайлангуудыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэх, үнэн зөв томилуулах үүрэгтэй. Удирдлагын тодорхойлох энэхүү дотоод хяналт нь санхүүгийн тайланг аливаа алдаа эсвэл залилангийн улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай байдаг.

Удирдлага нь Санхүүгийн тайланг бэлтгэхдээ Компанийн үйл ажиллагааг зогсоох юм уу татан буулгахаар төлөвлөсөн эсвэл ингэхээс өөр бодит сонголт байхгүй байхаас бусад тохиолдолд санхүүгийн тайлангуудыг гаргахдаа тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа зогсолтгүй явуулах компанийн чадамжийг үнэлэх, боломжтой бол тасралтгүй байх зарчимтай холбоотой асуудлуудыг тодруулах, нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг хэрэглэх үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Засаглах эрх мэдэл бүхий этгээдүүд нь Компанийн санхүүгийн тайлагналын үйл явцал хяналт тавих үүрэг хариуцлагатай байна.

Санхүүгийн Тайлангийн Аудитад хүлээх Аудиторын Үүрэг Хариуцлага

Залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийлэлээс санхүүгийн тайлан нь бүхэлдээ анхид эсэх талаарх үл үндэслэлтэй нотолгоо олж авах, дүгнэлт бүхий аудиторын тайлан гаргах нь бидний зорилго юм. Үл үндэслэлтэй нотолгоо гэдэг нь өндөр түвшний нотолгоо боловч АОУС-ын дагуу хийгдсэн аудитаар байгаа материаллаг буруу илэрхийллийг байнга илрүүлдэг гэсэн нотолгоо болохгүй. Буруу илэрхийлэх явдал нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох ба хэрэв тэр нь дангаараа эсвэл нийтдээ Санхүүгийн тайланд үндэслэн гаргасан хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай бол материаллагт тооцогддог.


С.БАДАМГАРАВ
ЭВИДЕНС-АУДИТ ХХК
Хоймор оффис 502 тоот Алтайн гудамж
Сүхбаатар дүүрэг, 9-р хороо,
Улаанбаатар хот, Монгол Улс

Огноо 2025.02.17

“ДАРХАН СЭЛЭНГИЙН ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ” ХК
2024 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн
АШИГ, АЛДАГДАЛ БОЛОН БУСАД ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

Үзүүлэлт	Тол	(төгрөгөөр)
		12/31/2024
Борлуулалтын орлого	5	148,508,757,364
Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	6	150,954,339,655
Нийт ашиг (алдагдал)		(2,445,582,291)
Бусад орлого	7	9,367,483,390
Ерөнхий ба удирдлагын зардал	8	1,280,839,732
Санхүүгийн зардал	9	53,376,355
Бусад зардал	10	4,686,469,396
Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	11	37,947,732
Үндсэн хоронго данснаас хассаны олз (гарз)	12	2,028,752
Татвар төлөхийн өмнөх нийт (алдагдал)		861,239,133
Орлогын татварын зардал		86,694,403
Татварын дараах ашиг (алдагдал)		774,544,730
Бусад дэлгэрэнгүй орлого		-
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)		774,544,730

Энэхүү Орлогын дэлгэрэнгүй тайланг 7-оос 34 дүгээр хуудсан дахь тодруулгуудын хамт утгах
бөгөөд тодруулгууд нь Санхүүгийн тайлангийн нэг хэсгийг бүрдүүлдэг.

“ДАРХАН СЭЛЭНГИЙН ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ” ХК
 2024 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн
САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

			(төгрөгөөр)	
	Үзүүлэлт	Тод	12/31/2023	12/31/2024
ХӨРӨНГӨ				
Эргэлтийн хөрөнгө				
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	13	360,132,329	159,865,432
	Дансны авлага	14	1,302,875,409	2,425,564,871
	Татварын авлага	15	57,373,386	80,000,000
	Бусад авлага	16	7,077,488,903	3,535,949,342
	Бараа материал	17	3,296,766,516	5,336,566,849
	Урьдчилж гарсан зардал	18	417,771,790	320,565,427
	Эргэлтийн хөрөнгийн дүн		12,512,408,333	11,858,511,922
Эргэлтийн бус хөрөнгө				
	Үндсэн хөрөнгө	19	103,303,109,882	105,739,673,853
	Бист бус хөрөнгө	20	732,669,869	718,220,463
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн		104,035,779,752	106,457,894,316
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН				
			116,548,188,085	118,316,406,238
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ				
Өр төлбөр				
Богино хугацаат өр төлбөр				
	Дансны өглөг	21	3,599,060,918	3,586,488,030
	Цалингийн өглөг	22	1,271,186,695	2,849,358,717
	Татварын өр	23	85,950,108	1,205,758,096
	НДШ-н өглөг	24	-	672,879,450
	Банкны богино хугацаат өр төлбөр	25	109,713,365	649,887,400
	Урьдчилж орсон орлого	26	1,071,302,970	20,000,000
	Богино хугацаат өр төлбөрийн дүн		6,137,214,056	8,984,371,694
Урт хугацаат өр				
	Урт хугацаат өр төлбөр	27	2,624,140,396	1,458,634,967
	Хойшлогдсон татварын өр төлбөр	28	12,620,249,889	12,148,048,489
	Урт хугацаат өр төлбөрийн дүн		15,244,390,285	13,606,683,456
	Өр төлбөрийн нийт дүн		21,381,604,342	22,591,055,150
Эздийн өмч				
	Өмч: /хувийн/		1,038,511,577	1,038,511,577
	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл		94,122,014,288	93,906,236,904
	Хуримтлагдсан ашиг		6,057,878	780,602,608
	Эздийн өмчийн дүн		95,166,583,743	95,725,351,088
ОР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН				
			116,548,188,085	118,316,406,238

Энэхүү Санхүү байдлын тайланг 10-оос 32 дугаар хуудсан дахь тодруулгуудын хамт унших
 бөгөөд тодруулгууд нь Санхүүгийн тайлангийн нэг хэсгийг бүрдүүлнэ.

“ДАРХАН СЭЛЭНГИЙН ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ” ХК
 2024 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн
ОМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

(төгрөгөөр)				
Үзүүлэлт	Хувьцаат капитал	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
12/31/2023	1,038,511,577	94,122,014,288	6,057,878	95,166,583,743
Өмчил гарсан өөрчлөлт				-
Дохин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн		(215,777,385)		(215,777,385)
Тайлант үеийн цэвэр ашиг/алдагдал/	-		774,544,730	774,544,730
12/31/2024	1,038,511,577	93,906,236,904	780,602,608	95,725,351,088

Энэхүү Омчийн өөрчлөлтийн тайланг 10-оос 32 дугаар хуудсан дахь тодруулгуудын хамт уншигч
 бичигд тодруулгууд нь Санхүүгийн тайлангийн нэг хэсгийг бүрдүүлнэ.

“ДАРХАН СЭЛЭНГИЙН ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ” ХК
 2024 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн
МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Үзүүлэлт	(төгрөгөөр) 12/31/2024
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	
Мөнгөн орлогын дүн (+)	137,060,431,594
Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	123,447,330,146
Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	2,612,206
Бусад мөнгөн орлого	13,610,489,241
Мөнгөн зарлагын дүн (-)	133,157,557,284
Ажилчдад төлсөн мөнгө	12,850,842,358
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	3,151,148,016
Бараа материал худалдан авахад төлсөн	13,653,481,460
Ашиглалтын зардал төлсөн	49,518,624
Түлш патахуун, сэлбэг хэрэгсэлд төлсөн	1,189,345,044
Хүүний төлбөрт төлсөн	6,494,311
Татварын байгууллагад төлсөн	2,380,678,219
Даатгалын төлбөрт төлсөн	74,749,809
Бусад мөнгөн зарлага	99,801,299,443
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээний дүн	3,902,874,310
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-
Мөнгөн орлогын дүн (+)	4,360,345
Хүлээн авсан хүүний орлого	4,360,345
Мөнгөн зарлагын дүн (-)	3,444,323,468
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	2,369,427,155
Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	338,453,250
Бусдад олгосон зээл болон урьдчилгаа	736,443,062
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээний дүн	(3,439,963,123)
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-
Мөнгөн зарлагын дүн (-)	663,178,084
Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	662,038,357
Валютын ханшийн тэгшитгэлийн алдагдал	1,139,727
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн дүн	(663,178,084)
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(200,266,897)
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(200,266,897)
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	360,132,329
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	159,865,432

Энэхүү Мөнгөн гүйлгээний тайланг 10-оос 32 дугаар хуудсан дахь тодруулгуудын хамт
 утгах бөгөөд тодруулгууд нь Санхүүгийн тайлангийн нэг хэсгийг бүрдүүлнэ.

Санхүүгийн тайлангийн тэмдэглэлүүд

1	Үйл ажиллагааны онцлог, ерөнхий мэдээлэл	10
2	Санхүүгийн тайлан бэлтгэсэн үндэслэл	11
3	Нягтлан бодох бүртгэлийн чухал тооцоолол ба шийдэл	11
4	Санхүүгийн хэрэглүүр-Эрсдийн удирдлага	13
5	Борлуулалтын орлого	16
6	Борлуулалтын өртөг	17
7	Бусад орлого	18
8	Ерөнхий удирдлагын зардал	18
9	Санхүүгийн зардал	18
10	Үйл ажиллагааны бус бусад зардал	19
11	Гадаад валютын ханшийн зөрүүний олз/(гарз)	19
12	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз/(гарз)	19
13	Мөнгө ба түүнтэй ашиглах хөрөнгө	20
14	Худалдааны болон бусад авлага	22
15	Татварын авлага	22
16	Бусад авлага	22
17	Бариа материал	23
18	Урьдчилж төлсөн зардал/ тооцоо	23
19	Үндсэн хөрөнгө	24
20	Бист бус хөрөнгө	25
21	Худалдааны болон бусад өглөг	25
22	Цалингийн өглөг	25
23	Бусад татвар, шимтгэлийн өглөг	26
24	НДШ-ийн өр төлбөр	26
25	Банкны богино хугацаат өр төлбөр	26
26	Урьдчилж орсон орлого	26
27	Урт хугацаат өр төлбөр	26
28	Хойшлогдсон татварын өр төлбөр	26
29	Болзоогүй өр төлбөр ба үүрэг хариуцлага	27
30	Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогууд	28
31	Балансын дараах үйл явдал	32

“ДАРХАН СЭЛЭНГИЙН ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ” ХК
2024 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД

1 Үйл ажиллагааны онцлог, ерөнхий мэдээлэл

“Дархан сэлэнгийн цахилгаан түгээх сүлжээ” ХК (Цаашид “Компани” гэх) нь 2005 оны 7-р сарын 21-ний өдрийн хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоолоор байлагдсан Компанийн дүрмийн Хувьцаат компани болон шинэчлэн зохион байгуулагдсан.

2005 оны 10-р сарын 11-ний өдөр Монгол улсын Улсын Бүртгэлийн Ерөнхий Газарт бүртгүүлж, Улсын бүртгэлийн 2688565 регистрийн дутаар бүхий 9010001004 тоот улсын бүртгэлийн гэрчилгээ авсан.

“Компани”-ийн үндсэн үйл ажиллагаа нь Цахилгаан эрчим хүч түгээх, цахилгаан эрчим хүчийг хангах, Цахилгаан эрчим хүчний шугам болон тоног төхөөрөмжийн үйлдвэрлэл, угсралт, засвар, үйлчилгээ хийх гадаад дотоод худалдаа эрхлэх зэрэг болно.

Эрчим хүчний тухай хуулийн 16 дугаар зүйлийн дагуу Эрчим хүчний зохицуулах газраас Дархан-Уул, Сэлэнгэ, Төв аймгийн нутаг дэвсгэрт Цахилгаан түгээх тусгай зөвшөөрлийг 2015 оны 10 сарын 26-ны өдрөөс 20 жилийн хугацаатай авсан.

Мөн Эрчим хүчний тухай хуулийн 17 дугаар зүйлийн дагуу Эрчим хүчний зохицуулах газраас Дархан-Уул, Сэлэнгэ, Төв аймгийн нутаг дэвсгэрт Цахилгаанаар зохицуулалтай хангах тусгай зөвшөөрлийг 2015 оны 10 сарын 26-ны өдрөөс 20 жилийн хугацаатай авсан.

2024 оны 12-р сарын 31-ний байдлаар хүчин төгөлдөр “Компани”-ийн дүрмийн дагуу хувьцаа эзэмшигчдийн хувьцаат капитал нь дараах байдалтай байна. Үүнд:

2024 оны 12 сарын 31

Тоо хэмжээ	Нэгж үнэ	Нийт үнэ
(ширхэг)	(төгрөг)	(Мян.төг)
10,385,116	100.00	1,038,511.6

“ДАРХАН СЭЛЭНГИЙН ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ” ХК
2024 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД (Үргэлжлэл)

2 Санхүүгийн тайлан бэлтгэсэн үндэслэл

Санхүүгийн тайлангуудын бэлтгэхэд ашигласан нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын хураангуйг Тэмдэглэл 25, Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын хураангуй-д толилуулсан. Өөрөөр тусгайлан зааснаас бусад тохиолдолд уг бодлогуудыг толилуулж буй бүх тайлант үеүдэд тууштай баримталж мөрдсөн болно.

Компанийн нягтлан бодох бүртгэлийн болон тайлагнагч валют нь Монгол улсын мөнгөн тэмдэгт болох Төгрөг юм. Эдгээр санхүүгийн тайлангууд нь төгрөгөөр илэрхийлэгдэж, мянган төгрөгөөр нарийвчлан харуулж тайлагнагдсан.

Эдгээр санхүүгийн тайлангуудыг Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Зовлол (НББОУСЗ)-оос гаргасан Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт, Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт болон тайлбарууд (хамтад нь “СТОУС” гэх)-ын дагуу бэлтгэсэн.

Санхүүгийн тайланг СТОУС-ын дагуу бэлтгэхэд тодорхой, чухал нягтлан бодох бүртгэлийн тооцоолол хийхийг шаарддаг. Мөн компанийн нягтлан бодох бүртгэлийн бодлогыг хэрэглэхэд удирдлагаас шийдэл гаргахыг шаарддаг. Санхүүгийн тайлан бэлтгэхэд хийгдсэн нөлөө бүхий шийдэл ба тооцоолол болон түүний нөлөөллийн талаар Тэмдэглэл 4, Нягтлан бодох бүртгэлийн чухал тооцоолол ба шийдэлд нэмж тодруулсан.

3 Нягтлан бодох бүртгэлийн чухал тооцоолол ба шийдэл

Компани нь ирээдүйн үйл ажиллагаатай холбоотой тодорхой тооцоолол ба төсөөлөл ашигладаг. Түүхэн туршлага болон үүссэн нөхцөл байдалд тохиромжтой гэж үзсэн ирээдүйн үйл ажиллагааны тухай таамаглал гэх мэт бусад хүчин зүйлсэд үндэслэн тооцоолол ба шийдлийг тогтмол үнэлдэг. Ирээдүйд бодит үр дүн нь тооцоолол ба төсөөллөөс ялгаатай байж болно. Дараагийн санхүүгийн жилүүдэд хөрөнгө, өр төлбөрийн давсны үнэд материаллаг нөлөө үзүүлж болохуйц нөлөө бүхий эрсдэлтэй тооцоолол ба төсөөллийг доор дурдлаа.

(а) Тасралтгүй үйл ажиллагаа

Компани өөдрөг төсөөллийн дагуу тасралтгүй ажиллана гэж санхүүгийн тайлан бэлтгэсэн

- Эргэлтийн хөрөнгө ба эргэлтийн өр төлбөрийн харьцаа 0.10 (2023 онд: 0.11);
- Өр төлбөр ба эздийн өмчийн харьцаа 0.24 (2023 онд: 0.22);
- Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа 0.05 (2023: 0.08) болж бага зэрэг бууралт гарсан байна.

“ДАРХАН СЭЛЭНГИЙН ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ” ХК
2024 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД (Үргэлжлэл)

(б) Үнэ цэнийн бууралт

Хоронго эсвэл хөрөнгийн мөнгө бий болгогч нэгжийн дансны үнэ нь эргэн похогодох дүнгээсээ давбал үнэ цэнийн бууралтын алдагдлыг хүлээн зөвшөөрнө. Эргэн талархах дүнг тогтоохдоо удирдлага нь хөрөнгө тус бүрийн эсвэл мөнгө бий болгогч нэгжийн ирээдүйн хүлээгдэж буй мөнгөн урсгалыг тооцоолж, эдгээр мөнгөн урсгалын өнөөгийн үнэ цэнийг тодорхойлохын тулд тохирох хүүг сонгож ашиглаах. Ирээдүйн хүлээгдэж буй мөнгөн урсгалыг хэмжихдээ удирдлага нь ирээдүйн үйл ажиллагааны үр дүнгийн талаар төсөөлөл гаргадаг. Энэ төсөөлөл нь ирээдүйд болох тодорхой нөхцөл байдал болон үйл явдлуудтай холбоотой болно. Бодит үр дүн нь өөр байж болох ба энэ нь дараагийн санхүүгийн жилд багтаж компанийн хоронгуудад хийгдэх томоохон залруулгуудын шалтгаан байж болно. Ихэнх тохиолдолд тохирох хөнгөлөлтийн түвшинг тодорхойлохдоо зах зээлийн эрсдэл болон хөрөнгөтэй холбоотой эрсдэлийн хүчин зүйлийн тохируулгыг хийдэг.

(в) Элэгдэх хөрөнгийн ашиглалтын хугацаа

Компанийн удирдлага нь хүлээгдэж буй хөрөнгийн ашиглалтад суурилан тайлант үе бүрийн эцэст биет бус хөрөнгө болон өмч, барилга, тоног төхөөрөмж гэх мэт элэгдэх хөрөнгийн ашиглалтын хугацааг шалгадаг. Гарсан үр дүн нь техникийн хуучралтын улмаас тооцоолол ба төсөөллөөс ялгаатай байж болно. Тэмдэглэл 25, Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын хураангуй-д Өмч, барилга, тоног төхөөрөмж болон Биет бус хөрөнгийн ашиглалтын хугацааны талаар дэлгэрэнгүй тусгасан.

(г) Бараа материал

Бараа материалыг өртөг, цэвэр боломжит үнийн аль багаар нь тусгана. Цэвэр боломжит үнэ цэнийг тооцохдоо тооцоолол хийх үеийн хамгийн найдвартай бэлэн байгаа нотолгоог авч үздэг.

Бараа материалын дансны үнийн ирээдүйд гарах өөрчлөлт нь зах зээлийн үнийн өөрчлөлтөөс шалтгаална.

(д) Болзошгүй зүйлс

Ирээдүйд нэг эсвэл хэд хэдэн тодорхойгүй үйл явдал тохиолдохоор бол болзошгүй зүйлсийг тусгадаг. Ирээдүйн үйл явдлын үр дүнгийн талаарх дүгнэлтийн хэрэглээ, үр ашигтай шийдлийг хэрэгжүүлэх зэрэг нь болзошгүй байдал оршин буй эсэхийн үнэлгээ болдог.

“ДАРХАН СЭЛЭНГИЙН ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ” ХК
2024 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД (Үргэлжлэл)

(e) Бодит үнэ цэнийн хэмжилт

Компанийн санхүүгийн тайланд хэд хэдэн хөрөнгө, өр төлбөрийг бодит үнэ цэнээр нь хэмжиж, тодруулахыг таарддаг. Компанийн санхүүгийн ба санхүүгийн бус хөрөнгө, өр төлбөрийн бодит үнэ цэнийн хэмжилтэд ажиглагдахуйц өгөгдлийг аль болох их хэмжээгээр хэрэглэдэг. Бодит үнэ цэнийн хэмжилтэд хэрэглэгддэг өгөгдлийг ажиглагдахуйц байдлаар нь гурван түвшинд ангилдаг (“бодит үнэ цэнийн шатлал”):

- *Түвшин 1:* Идэвхтэй зах зээл дэх нжил төстэй зүйлсийн жишиг үнэ (тохируулга хийгдээгүй)
- *Түвшин 2:* Түвшин 1-ээс бусад ажиглагдахуйц шууд эсвэл шууд бус өгөгдөл
- *Түвшин 3:* Үл ажиглагдахуйц өгөгдөл (зах зээлийн бус мэдээлэл).

Өгөгдсөн зүйлсийн бодит үнэ цэнийн хэмжилтэд томоохон нөлөө үзүүлэх хэрэглэсэн өгөгдлийн өгөгдлийн хамгийн бага түвшинд үндэслэн зүйлсийг дээрх түвшинд ангилдаг. Түвшин хооронд зүйлсийг шилжүүлэхдээ шилжүүлсэн үед нь хүлээн зөвшөөрнө.

Компани нь дараах зүйлсийг бодит үнэ цэнээр нь хэмждэг.

4 Санхүүгийн хэрэглүүр-Эрсдэлийн удирдлага

Компани нь үйл ажиллагаагаараа дамжуулж дараах эрсдэлүүдэд өртөж байдаг:

- а) Зээлийн эрсдэл
- б) Зах зээлийн эрсдэл
 - i) Хүүгийн түвшний эрсдэл,
 - ii) Гадаад валютын эрсдэл,
 - iii) Бусад зах зээлийн үнийн эрсдэл
- в) Төлбөрийн чадварын эрсдэл.

Бусад бүх бизнесийн пэгэн ажил Компани нь санхүүгийн хэрэглүүр хэрэглэснээс үүдэлтэй эрсдэлд өртдөг. Энэ тэмдэглэлд Компанийн эрсдэлийн удирдлагын бодлого, энэхүү эрсдэлийг зохицуулах процесс ба түүнийг хэмжих аргуудыг тайлбарласан. Эдгээр эрсдэлтэй холбоотой нэмэлт тоон мэдээллүүдийг санхүүгийн тайланд зохих ёсоор толилуулсан.

Энэхүү тэмдэглэлд оороор дурдаагүй л бол Компанийн санхүүгийн хэрэглүүрийн эрсдэлд өртөмхий байдал, эдгээр эрсдэлийг зохицуулахад чиглэсэн зорилт, бодлого ба процесс болон түүнийг хэмжихэд хэрэглэгдсэн бодлогод өмнөх жилүүдтэй харьцуулахад ямар нэгэн биег өөрчлөлт ороогүй болно.

(i) Санхүүгийн үндсэн хэрэглүүрүүд

Санхүүгийн хэрэглүүрийн эрсдэл үүсгэдэг дараах үндсэн санхүүгийн хэрэглүүрүүдийг Компани хэрэглэдэг:

- Худалдааны болон бусад авлага
- Монго ба түүнтэй адилтгах хөрөнгө
- Худалдааны болон бусад өглөг
- Урт болон богино хугацаат зээл

"ДАРХАН СЭЛЭНГИЙН ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ" ХК
2024 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД (Үргэлжлэл)

(II) Бодит үнэ цэнээр хэмжигддэггүй санхүүгийн хэрэглүүр

Бодит үнэ цэнээр хэмжигддэггүй санхүүгийн хэрэглүүрт мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө, худалдааны болон бусад авлага, худалдааны болон бусад өглөг болон зээлийн өглөг багтана.

Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө, худалдааны болон бусад авлага, худалдааны ба бусад өглөг нь богино хугацаат шинж чанартай байдаг тул тэдний дансны үнэ цэнэ нь бодит үнэ цэнтэйгээ ойролцоо байдаг.

Ерөнхий Зорилго, Бодлого ба Процесс

Удирдлага нь компанийн эрсдэлийн удирдлагын зорилго, бодлогыг тодорхойлж түүнд үндсэн үүрэг хариуцлага хүлээхийн зэрэгцээ компанийн санхүүгийн үйл ажиллагааны зорилго, бодлогыг үр дүнтэйгээр хэрэгжүүлэх процессыг боловсруулж, үйл ажиллагааг нь явуулах эрх мэдэлтэй байдаг.

Компанийн эрсдэлийн удирдлагын үүрэгт санхүүгийн эрсдэл, үйл ажиллагааны эрсдэл, хууль эрх зүйн эрсдэлүүд багтдаг. Санхүүгийн эрсдэл нь зах зээлийн эрсдэл (үүнд гадаад валютын эрсдэл, хүүгийн эрсдэл, болон бусад үнийн эрсдэл), зээлийн эрсдэл болон төлбөрийн чадварын эрсдэлээс бүрдэнэ. Санхүүгийн эрсдэлийн удирдлагын үндсэн зорилго нь хүлээх эрсдэлийн хязгаарлалтыг тогтоож, хүлээсэн эрсдэлийн хэмжээг тогтоосон хязгаарлалтаас хэтрүүлэхгүй байлгахад оршино. Үйл ажиллагааны болон эрх зүйн эрсдэлийн удирдлагын үйл ажиллагаа нь, дотоод бодлого, журам, хэвийн үйл ажиллагааг хангах болон үйл ажиллагааны болон хууль эрх зүйн эрсдэлийг багасгах зорилготой.

а) Зээлийн эрсдэл

Компанийн харилцагч ба хамтрагч тал нь гэрээгээр хүлээсэн төлбөрийн үүргээ хугацаанд нь биелүүлээгүйн улмаас санхүүгийн алдагдал хүлээх эрсдэлийг зээлийн эрсдэл гэнэ. Компани нь зээлийн борлуулалтаас үүдэлтэй эрсдэлд голчлон өртөж байна. Компани шинэ харилцагчтай гэрээ байгуулахын өмнө түүний зээлийн эрсдэлийг үнэлэх бодлого баримталдаг. Энэхүү зээлийн үнэлгээг бизнесийн үйл ажиллагаандаа ашигладаг. Компанийн санхүүгийн хэлтсээс худалдааны авлагын үлдэгдэлд насжилтын шинжилгээ хийж хяналт тавьдаг бөгөөд хугацаа хэтэрсэн үлдэгдлийг төлүүлэх арга хэмжээ авч ажилладаг. Иймээс зээлийн эрсдэлийн насжилтын болон бусад мэдээллээр хашгаж байхыг зохистой гэж удирдлага үздэг.

б) Зах зээлийн эрсдэл

Хүүтэй, арилжаалагдах болон гадаад валютаар илэрхийлэгдсэн санхүүгийн хэрэглүүр хэрэглэснээс үүдэлтэйгээр компани зах зээлийн эрсдэлд өртдөг. Энэ нь хүүгийн түвшин (хүүгийн түвшний эрсдэл), гадаад валютын ханш (гадаад валютын эрсдэл) эсвэл зах зээлийн бусад хүчин зүйлсэд (бусад үнийн эрсдэл) гарсан өөрчлөлтийн улмаас санхүүгийн хэрэглүүрийн бодит үнэ цэнэ эсвэл ирээдүйн мөнгөн гүйлгээ хэлбэлзэх эрсдэл юм.

"ДАРХАН СЭЛЭНГИЙН ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ" ХК
2024 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД (Үргэлжлэл)

i) Хүүгийн түвшний эрсдэл

Хүүгийн түвшний эрсдэл гэдэг нь зах зээл дэх зээлийн хүүгийн түвшний өөрчлөлтийн улмаас санхүүгийн хэрэглүүрийн бодит үнэ цэнэ эсвэл ирээдүйн мөнгөн гүйлгээ хэлбэлзэх эрсдэл юм.

ii) Гадаад валютын эрсдэл

Гадаад валютын эрсдэл гэдэг нь гадаад валютын ханшийн өөрчлөлтийн улмаас санхүүгийн хэрэглүүрийн үнэ цэнэ хэлбэлзэх эрсдэл юм. Ирээдүйн ажил гүйлгээ, хүлээн зовшоорогдсон хөрөнгө, өр төлбөр Монгол Төгрөгөөс өөр валютаар илэрхийлэгдсэн тохиолдолд гадаад валютын эрсдэл үүсдэг. Компани 2022 онд 800,000 ам долларын зээл авсан тул гадаад валютын эрсдэлд орж болзошгүй.

iii) Бусад зах зээлийн үнийн эрсдэл

Компани зах зээлийн үнийн хэлбэлзлээс ашиг хүртэх зорилгоор аливаа өрийн болон өмчийн хэрэглүүр эзэмшдэггүй учир зах зээлийн үнийн эрсдэлд өртөхгүй гэж үзэж байна.

а) Төлбөрийн чадварын эрсдэл

Төлбөрийн чадварын эрсдэл нь аливаа аж ахуйн нэгж нь санхүүгийн өр төлбөрийг барагдуулах үүргээ биелүүлэхэд хүндрэл үүсэх эрсдэлийг илэрхийлнэ. Энэ нь Компани санхүүгийн өр төлбөрөө хугацаанд нь төлж барагдуулахад хүндрэлтэй тулгарах эрсдэл юм.

Компанийн бодлого нь өр төлбөр төлөх хугацаа болоход хангалттай бэлэн мөнгөтэй бийх явдал юм. Энэ зорилгод хүрэхийн тулд Компани нь хүлээгдэж буй шаардлагыг биелүүлэхийн тулд тогтмол бэлэн мөнгөний үлдэгдэлтэй (эсвэл харилцан тохиролцсон хэрэглүүр) бийх явдал юм. Төлбөрийн чадварын эрсдэл нь Компанийн мөнгөн урсгалыг удирдах чадвараас үүсдэг.

“ДАРХАН СЭЛЭНГИЙН ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ” ХК
 2024 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД (Үргэлжлэл)

5 Борлуулалтын орлого

Орлого үр дүнгийн тайланд тусгасан борлуулалтын орлого нь дараах зүйлсээс бүрдэнэ.

Үзүүлэлт	12/31/2024
Борлуулалтын орлого-Төсөвт байгууллага	5,492,543,046
Борлуулалтын орлого-Аж ахуйн нэгж байгууллага	27,571,322,207
Борлуулалтын орлого- Гэр хороололын хэрэглэгчид	12,485,192,079
Борлуулалтын орлого-Орон сууц хороололын хэрэглэгчид	6,258,367,471
Борлуулалтын орлого- Бусад	96,701,332,561
Нийт дүн	148,508,757,364
Дархан салбарын орлого	27,494,586,407
Сүхбаатар салбарын орлого	9,716,022,590
Зүүнхараа салбарын орлого	7,907,907,737
Хөтөл салбарын орлого	2,786,521,286
Жаргалант салбарын орлого	3,902,386,783
Бусад орлого	96,701,332,561
Нийт дүн	148,508,757,364

“ДАРХАН СЭЛЭНГИЙН ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ” ХК
 2024 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД (Үргэлжлэл)

6 Борлуулалтын өртөг

Үзүүлэлт	12/31/2024
Борлуулалтын бүтээгдэхүүний өртөг-Төсөвт байгууллага	7,707,307,395
Борлуулалтын бүтээгдэхүүний өртөг -Аж ахуйн нэгж байгууллага	42,277,946,625
Борлуулалтын бүтээгдэхүүний өртөг - Гэр хороололын хэрэглэгчид	28,033,452,219
